

Инно хими лаб ХХК



ИННО ХИМИ ЛАБ ХХК

МЭДЭЭЛЛИЙН НЭР:

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД
2014 ОНООС МӨРДӨЖ ЭХЭЛСЭН
“ХҮНС, ЭМИЙН ШИНЖИЛГЭЭ
ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ”, ХЯНАЛТ
ХИЙХ ЧАДАМЖТАЙ
ЛАБОРАТОРИУДЫГ СОНГОН
ШАЛГАРУУЛДАГ ҮЙЛ ЯВЦ**

Албан бус орчуулга

Утас: 77051414

И-мэйл: info@innocem.mn

Вэбсайт: www.medimpex.mn

Фэйсбүүк:


Инно лаборатори
Agilent Demo Center

Мэдээллийн эх сурвалж: https://www.mfds.go.kr/eng/wpge/m_55/de011038I001.do

Хүнс, эмийн шинжилгээ хяналтын тухай хууль болон энэхүү хуулийн хүрээнд хүнс эмийн шинжилгээ, хяналт хийх чадамжтай лабораториудыг сонгон шалгаруулдаг үйл явцын талаарх товч танилцуулга

Солонгос улсын аюултай хүнсний худалдаанаас урьдчилан сэргийлэх систем

Хүнс, эмийн аюулгүй байдлын яам хүнс, эмийн шинжилгээний лабораториудтай шууд цахим системээр холбогдож шинжилгээний үр дүнгийн мэдээллийг авна.



Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүнс, эмийн шинжилгээ шалгалтын хуулийн талаарх товч танилцуулга

Хүнс, эмийн шинжилгээ шалгалтын хуулийн зорилго нь хүнсний бүтээгдэхүүн, эм, бэлдмэлийн шинжилгээ шалгалтыг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн шинжилгээ, шалгалтын найдвартай баталгаатай байдлыг хангах шинжилгээний технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, энэ салбарыг хөгжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад лабораториуд чухал үүрэг хариуцлагатайгаар оролцдог болгоход оршдог байна. Энэхүү хуулийн хүрээнд шинжилгээний лабораториудыг томилох, шинжилгээний байгууллагуудын чадамжийг өндөр түвшний шаардлагад нийцүүлэх үүднээс зохих менежментийг хийх, энэхүү салбарт ажиллах боловсон хүчнийг сургах, хөгжүүлэхэд боловсролын салбарыг татан оролцуулах асуудлуудыг зохицуулдаг.

Тодруулбал, Хүнс, эмийн аюулгүй байдал (ХЭАБ)-ын сайд хүнс, эмийн шинжилгээ, шалгалт болон холбогдох салбарыг хөгжүүлэх таван жилийн үндсэн төлөвлөгөөг Хүнс, эмийн шинжилгээ, хяналтыг хөгжүүлэх Зөвлөлдөх хорооны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр боловсруулан хэрэгжүүлэх ёстой.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд ХЭАБ-ын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтыг хөгжүүлэх Зөвлөлдөх хороог байгуулахаар зааж өгсөн байна. Үүнд:

1. Шинжилгээ шалгалтын үндсэн төлөвлөгөөтэй холбоотой асуудлууд
2. Шинжилгээ, шалгалттай холбоотой шинжилгээ, шалгалтын менежментийн систем болон бодлого
3. Хүнс, эмийн аюулгүй байдлын сайдын хүрээнд авч хэлэлцсэн шинжилгээ, шалгалтын тухай бусад асуудал

Энэ талаар 5 бүлэгт хамаарах 30 зүйл бүхий дараах хэсгүүд орно. Үүнд:

- I. Ерөнхий заалт
- II. Шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг томилох
- III. Шинжилгээ, шалгалтын байгууллагуудын чадавхийн тогтолцоо, удирдлага
- IV. Нэмэлт заалтууд
- V. Зөрчлийн заалтууд

Энэхүү хуулийн 4 дүгээр зүйлд заасан Шинжилгээ, шалгалтын хөгжлийн үндсэн төлөвлөгөөнд дараах асуудлуудыг тусгах ёстой хэмээн заажээ. Үүнд:

1. Шинжилгээ, шалгалтын талаар авч хэрэгжүүлэх бодлогын зорилго, чиглэл
2. Шинжилгээ, шалгалтыг дэмжих дунд болон урт хугацааны төлөвлөгөө
3. Шинжилгээ, шалгалт, хүний нөөцийг хөгжүүлэх талаарх мэдээлэл, судалгаа, авах арга хэмжээ
4. Шинжилгээ, шалгалтын нарийвчлал, нарийвчлалыг нэмэгдүүлэх тухай мэдээлэл
5. Шинжилгээ, шалгалтын талаарх олон улсын хамтын ажиллагааны тухай мэдээлэл
6. Шинжилгээ, шалгалтыг хөгжүүлэхэд шаардлагатай бусад мэдээлэл

Хуулийн 6 дугаар зүйл нь Шинжилгээний лабораториудыг томилох тухай бөгөөд энэхүү эрхийг Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны сайдад олгож энэ эрхийн хүрээнд шинжилгээ, шалгалт хийх мэргэжлийн, үр дүнтэй гүйцэтгэх чадамжтай “шинжилгээний лаборатори” -ийг томилно хэмээн заасан.

Энэ хуулийн 7 дугаар зүйлд импортын бараа бүтээгдэхүүнд шинжилгээ хийх эрхийг гадаад улс орны лабораториудад олгох талаар заасан.

Хуулийн 11 дугаар зүйлд ХЭАБЯ-аас томилогдсон лабораториудын шинжилгээний үр дүнд үл тохирол буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс өөр гарсан тохиолдолд ХЭАБЯ-ны Сайдын баталсан журмын дагуу нэн даруй мэдэгдэх ёстой хэмээн заасан.

Хуулийн 12 дугаар зүйлд ХЭАБЯ-ны Сайдын баталсан журмын дагуу Жил бүрийн шинжилгээний үр дүнгийн тайланг лабораториуд хүргүүлэх ёстой.

Лабораторийн Мэдээллийн Менежментийн Системийг ашиглах тухай Хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар ХЭАБЯ-ны сайд шинжилгээ, шалгалтын дата мэдээллийг үр дүнтэй удирдаж менежмент хийхийн тулд лабораторийн мэдээллийн менежментийн системийг бий болгож ажиллуулах талаар тусгаж өгсөн. Харин энэхүү системийг хэрхэн ажиллуулж удирдах нь тусгай журмын хүрээнд зохицуулна гэжээ.

Хуулийн гуравдугаар бүлэг нь Шинжилгээний лабораториудын чадамжийг удирдах буюу хэрхэн лабораториудын чадамжийг сайжруулах, илүү сайн хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилготой байна. Энэ бүлгийн 15 дугаар зүйлд ХЭАБЯ-аас шинжилгээний лабораториудын үйл ажиллагааны системийг бий болгох, хөгжүүлэх, байнгын ажиллагаатай байлгахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ хэмээн заажээ. Үүнд:

1. Шинжилгээ, шалгалтын техник аргачлалын нарийвчлал, тогтвортой байдлыг сайжруулах ажлууд
2. Үндэсний стандартын тухай хуулийн 3.17 дахь заалтын дагуу шинжилгээ, шалгалтын багаж тоног төхөөрөмжийн хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах ажлууд
3. Шинжилгээ, хяналт хийдэг байгууллагуудын найдвартай баталгаатай байдлыг нэмэгдүүлэх үйл ажлууд
4. Шинжилгээ, шалгалт явуулах системийн чадамжийн түвшинг нэмэгдүүлэх
5. Шинжилгээ, хяналтанд ашигладаг стандартын бүтээгдэхүүн, дээжийг үйлдвэрлэх, хэрэглэх үйл ажиллагаа

Хуулийн 17 болон 18 дугаар зүйлүүдэд шинжилгээ, хяналтыг хийж буй ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхийн тулд ХЭАБЯ-аас мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах, ажилд авах зэрэг талаар тусгай бодлого хэрэгжүүлэх, мөн сургалтанд хамруулах, сургалт явуулах сургалтын байгууллагыг сонгох зэрэг үйл ажиллагаануудын талаар заалтуудыг оруулсан байна.

Хуулийн 19 болон 20 дугаар зүйлд шинжилгээний лабораториудын үйл ажиллагааг зогсоох, олон нийтэд хохирол учруулсан тохиолдолд 200 сая хүртэлх воноор торгох, хуулийн хариуцлага тооцох тохиолдлуудыг зүйлчлэн зааж өгсөн.

Хуулийн дөрөвдүгээр бүлэг нь энэ хуулиар зохицуулагдах нэмэлт дүрмүүд, тавдугаар бүлэг нь Зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн арга хэмжээнүүдийг тусгажээ.

✚ Дараах сайтнаас шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг хянах үйл явцын талаар болон шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллүүдийг авах боломжтой:

https://www.mfds.go.kr/eng/wpge/m_55/de0110381001.do

Шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг хянах үйл явц

Мөрдөх хууль эрх зүйн актууд

- Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын тухай хууль
- Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх дүрэм
- Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг үнэлэх журам

| Ангилал | Хууль | Хэрэгжүүлэх дүрэм | Мэдэгдэл |
|---|----------------------|---------------------------------------|--|
| Шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг томилох | 6-р зүйл (1) (4) (6) | 2-р зүйл (Хавсралт 1) (Хавсралт 2) | Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын байгууллагын үнэлгээний тухай журам |
| Шинжилгээ, шалгалтын байгууллагуудыг өөрчлөх | 6-р зүйл (5) (6) | 4-р зүйл (5) (6) | Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын байгууллагын үнэлгээний тухай журам |
| Шинжилгээ, шалгалтыг явуулах үйл явц | 11-р зүйл | 11-р зүйл, 12-р зүйл, | - |
| Шинжилгээ, шалгалтын байгууллагын ажиглах асуудлууд | 12-р зүйл | 15-р зүйл (Хавсралт 6) | - |
| Шинжилгээ, шалгалтын байгууллагын үнэлгээ болон менежмент | 16-р зүйл | 20-р зүйл | Хүнс, эмийн шинжилгээ, шалгалтын байгууллагын үнэлгээний тухай журам |

| | | | |
|--|-----------|---|---|
| Шинжилгээ, шалгалтын байгууллагыг Шалгах | 22-р зүйл | - | - |
|--|-----------|---|---|

✚ Хүнс, эмийн аюулгүй байдлын шинжилгээ, шалгалтын хуулийн 6 дугаар зүйлд Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны сайд шинжилгээ, шалгалт хийх байгууллагыг томилно гэж заасны дагуу Сайдын тушаалаар хянаж баталгаажуулах үйл явцыг зохицуулдаг байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг (Inspection Procedures of Testing and Inspection Agencies) дараах холбоосоор (https://www.mfds.go.kr/eng/wpge/m_55/de0110381001.do) авч болно.

✚ Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны Сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу шинжилгээ, шалгалт явуулах лаборатори нь шаардлага хангасан байгууламж, тоног төхөөрөмж, хүн хүчтэй байх ёстой бөгөөд журманд заасны дагуу өргөдөл гаргаж баталгаажуулах ёстой гэсэн байна. Өргөдөл гаргахын тулд онлайн сайтад байрлуулсан мэдээллүүдийг шинжилгээний лабораторид ирүүлэх ёстой бөгөөд **доорх хэсэгт зөвхөн эхний хэсгийг** орчуулан хүргэж байна. Үүнд:


1. Хүнс, эмийн шалгалтын шинжилгээ лабораториор сонгогдох хүсэлтийн өргөдөл
2. Лабораторийн зохион байгуулалт, лабораторийн ажилтнууд (ажлын туршлагыг оруулах)
3. Шинжилгээний байгууламжийн зураглал
4. Шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, төхөөрөмжийн жагсаалт (лабораторийн зураглал дээр тусгасан байна)
5. Дараах мэдээллийг агуулсан бизнесийн үйл ажиллагааны журам
 - Шинжилгээ/хяналтын хугацаа
 - Чанарын баталгаажуулалтын стандарттай холбоотой баримт бичиг
 - Шинжилгээ/хяналт шалгалтын хураамж, хураамжийг тооцох арга
 - Эмнэлгийн хэрэгслийн хувьд төлбөр, тооцох аргачлалыг хүнс, эмийн аюулгүй байдлын Сайдын тушаалаар тогтоосон Эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд нийцүүлэн тооцно.
 - Лабораторийн амьтдыг арчлах, удирдах стандарт, заавар *Зөвхөн лабораторийн амьтдыг ашиглан судалгаа хийдэг лабораторид хамаарна.
 - Органо-лептикийн шинжилгээнд зориулж шинжээчдийн удирдлага, дээж цуглуулах стандартууд *Зөвхөн импортын ургамлын гаралтай эмийн органолептик шинжилгээнд хамаарна
 - Лабораторийн ажилтан, шинжилгээний багаж хэрэгсэл түүнийг дагалдах өгөгдөлд тулгуурласан шинжилгээ, хяналтын оновчтой тоо (Хүнс, эмийн шинжилгээ, хяналт шалгалтын тухай хуулийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 2-р зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан)
6. Чанарын баталгааны үнэлгээ
7. Шинжилгээний чадамжийн үнэлгээ

Шинжилгээ шалгалт явуулах эрх бүхий байгууллагуудын жагсаалтыг Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны дараах сайтаас харна. [/www.mfds.go.kr](http://www.mfds.go.kr) > Customer Risk Prevention > A list of testing-inspection Agencies/

Бусад мэдээллийг та бүхэн энэхүү цахим хаягаар орж танилцаарай
https://www.mfds.go.kr/eng/wpge/m_55/de0110381001.do

Солонгос улсын аюултай хүнсний худалдаанаас урьдчилан сэргийлэх систем

Энэхүү зураглалд Хүнс, эмийн аюулгүй байдлын яам хүнс, эмийн шинжилгээний лабораториудтай шууд цахим системээр холбогдож шинжилгээний үр дүнгийн мэдээллийг авдаг байна.



Энэ зургийг тайлбарлавал аюултай хүнсний бүтээгдэхүүний борлуулалтыг хязгаарлах системийн урсгал болохыг харуулж байна.

Гол оролцогч талууд ба хамрах хүрээ:

1. Хүнс, эмийн аюулгүй байдлын яам

- Бүтээгдэхүүний мэдээлэл, аюултай хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний үр дүнг интернэтээр дамжуулан мэдээлдэг.

2. Системийн хэсэг

- Холбох систем
- Аюултай хүнсний портал вэбсайт
- Өндөр баталгаатай имэйл сүлжээ

3. Дистрибутер болон хэрэглэгчид

- Дистрибутерийн төв байр аюултай хүнсний мэдээллийг шалгана.
- Аюултай хүнсний бүтээгдэхүүний мэдээллийг үйлдвэрлэгч болон хэрэглэгчдэд хүргэнэ.

4. Борлуулалтын хяналт

- Дэлгүүрийн ПОС (кассын систем) аюултай хүнсийг борлуулахыг хязгаарлана.
- Аюултай хүнс борлуулагдахгүйгээр зогсоогддог.

Энэ системд лабораторийн үүрэг, оролцоог дэлгэрүүлэн харуулвал:


1. Шинжилгээ хийх

- Аюултай хүнсний бүтээгдэхүүнд шинжилгээ хийх (химийн, биологийн, физик шинжилгээ)
- Пестицид, хүнд металл, нянгийн бохирдол, хүнсний нэмэлтийн хэмжээг тогтоох

2. Мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах

- Лабораторийн шинжилгээний үр дүнг боловсруулах
 - Аюултай эсэхийг үнэлэх, хуулийн зохицуулалттай харьцуулах
 - Тайлан боловсруулах
3. **Мэдээлэл дамжуулах**
- Хүнс, эмийн аюулгүй байдлын яам руу мэдээллийг дамжуулах
 - Дистрибьютерт мэдээлэл хүргэх
 - Хувь хүн, бизнес, хэрэглэгчдэд аюултай хүнсний талаар анхааруулга өгөх
4. **Борлуулалтын хяналтад нөлөөлөх**
- Аюултай хүнсний бүтээгдэхүүний борлуулалтыг хязгаарлах мэдээллийг системд оруулах
 - Дэлгүүрийн ПОС болон дистрибьютертэй холбогдон, хяналт тавих

Дээрх системийг хураангуйлан харуулвал:



Лабораторийн **шинжилгээний урсгал** (шинжилгээ → үнэлгээ → дүгнэлт → мэдээлэл дамжуулах)

- Мэдээлэл **дамжуулах систем** (Лаборатори → Яам → Дистрибьютер → Дэлгүүр)
- Борлуулалтын **хяналт** (Шинжилгээнд суурилсан хязгаарлалт)

Лабораторийн шинжилгээний үр дүнд суурилсан хяналт, бодлого боловсруулах тогтолцоо ажиллаж бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж байгааг харж болохоор байна.

Инно Хими Лаб ХХК – ийн танилцуулга:


Үйлчилгээний нэр төрөл:

- Хүнс, хүрээлэн буй орчны шинжилгээний лабораторийн шинжилгээ
- Химийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, урвалжийн худалдаа
- Химийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ
- Химич, химийн мэргэжилтний сургалт, зөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр төрөл:

- Тоног төхөөрөмж
- Багаж хэрэгсэл
- Урвалж, уусмал
- Стандарт бодис, оношлуур
- Химийн бодис
- Шил сав, дагалдах хэрэгсэл

Хэрэглэгчидийнхээ цаг завьг хэмнэх, тасралтгүй ажиллагааг дэмжих үүднээс www.innochem.mn онлайн худалдааны сайтыг нэвтрүүлээд байна.



Инно лаборатори

- Химийн лабораторийн мэргэжилтнүүдэд өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах орчин бүрдүүлэх, чадамжийг сайжруулах
- Хүнсний болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад лабораторийн шинжилгээг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж хувь нэмрээ оруулах

Шинжилгээний хүрээ:

- Пестицидийн үлдэгдлийн шинжилгээ
- Усанд болон тосонд уусдаг витаминь шинжилгээ
- Хүрээлэн буй орчны бохирдлын шинжилгээ